- ✓ Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2
- ✓ Хэвлэмэл хуудас хүчингүй болгох, устгах тухай 1
- ✓ Сар шинийн баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх тухай 1
- ✓ Тушаал хүчингүй болгож, Газрын тамга, тэмдэг түших, хэвлэмэл хуудас хариуцан ажиллах тухай 1
- ✓ Хөтөлбөр баталж, зардал гаргах тухай 1
- ✓ "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын хаяг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх тухай 1
- ✓ Зардал гаргах тухай 1
- ✓ Дүрэм шинэчлэн батлах тухай 1
- ✓ Ажил эхлэх, дуусах цаг болон зайнаас цахим сүлжээгээр ажиллах хуваарь, журам батлах тухай 1
- ✓ Бусад 5

Газрын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан тушаалуудын харьцуулалт:




График 3.3-2

Газрын боловсон хүчний чиглэлээр батлагдсан 64 тушаал байна. Үүнд:

- ✓ Чөлөө олгох тухай 17
- ✓ Ажилд томилох (туршилт, туршилтын хугацаа сунгах) тухай 10
- ✓ Тусламж олгох тухай 7
- ✓ Ажлаас чөлөөлөх тухай 4
- ✓ Жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай 4
- ✓ Гэрээгээр ажиллуулахтай холбогдолтой тухай 3
- ✓ Сахилгын шийтгэл ногдуулах тухай 4
- ✓ Чөлөөний хугацаа сунгах тухай 3
- ✓ Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож, албан тушаалд томилох тухай 3
- ✓ Дэмжлэг олгох тухай 2
- ✓ Хүүхэд асрах чөлөөний хугацаа сунгах тухай 2
- ✓ Сургалтад оролцох, хамрагдах тухай 2
- ✓ Ээлжийн амралт болон орлон гүйцэтгэх хуваарь батлах тухай 2
- ✓ Албан үүрэг түр гүйцэтгүүлэх тухай 1

Хүний нөөцийн чиглэлээр гарсан тушаалуудын харьцуулалт




График 3.3-3

Газрын даргын 2025 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан ажилтнуудын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийн 2026 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 02-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн биелэлт 1 дүгээр улирлын байдлаар 92.8 хувь, хагас жилийн байдлаар 96.9 хувьтай хэрэгжсэн байна.

Тайлант хугацаанд дараах 4 удаагийн төлбөртэй сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 245 албан хаагч хамрагдаж, 5,140,000 төгрөг зарцуулав. Үүнд:

- ✓ "Монгол бичгийн" дунд шатны 30 цагийн багц сургалтад 89 ажилтан, 2,340,000 төгрөг,
- ✓ "Ажлын байрны стрессийн менежмент" сургалтад 50 ажилтан, 500,000 төгрөг,
- ✓ "Цахим хөгжил ба AI" цахим сургалтад 60 ажилтан, 1,300,000 төгрөг,
- ✓ "Олон улсын стандартын MNS ISO 9001:2015, MNS ISO 21500:2017" сургалтад 46 ажилтан, 1,000,000 төгрөг.

Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хөдөлмөрийн "дотоод журам" шинэчлэн батлах тухай А/47 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 10.13 дахь хэсгийг "...Ажилтанд хоол унааны мөнгийг ажлын өдрөөр тооцон тухайн жилийн төлөвлөгөөг үндэслэн олгож болно" гэж газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/66 дугаар тушаалаар өөрчлөлт оруулан батлаж, хэрэгжилтийг ханган тайлант хугацаанд хоолны мөнгө 177,740,000, унааны мөнгө 133,305,000, нийт 311,045,000 сая төгрөгийг олгов.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, газрын Хөдөлмөрийн "дотоод журам"-ын холбогдох заалтын хүрээнд 9 ажилтанд 17,100,000 төгрөгийн тусламжийг газрын даргын тушаалаар баталгаажуулав.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган www.shilendans.gov.mn цахим сайтад:

- ✓ Газрын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл 6 удаа,
- ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл үүсээгүй тухай мэдээлэл 5 удаа тус тус байршуулав.

3.4. Газрын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралт, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны "Аргачлал, загвар батлах тухай" 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу нийт 95 албан хаагч 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын дарга, хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллав. Тус тушаалын 6 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 89 албан хаагч хагас жилийн байдлаар 06 дугаар сарын 03-ны өдөр тайлагнаж, газрын дарга, хэлтсийн дарга нар үнэлж, дүгнэв.

Ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулж, алба хаагчдын үнэлгээний нэгтгэлийг "Үнэлгээний баг"-ийн баталгаажуулав. "Үнэлгээний баг"-ийн хурлын шийдвэрийг газрын даргад танилцуулан, нэгдсэн үнэлгээг баталгаажуулав.

Албан хаагчдын үнэлгээний хуудсыг газрын дарга, "Үнэлгээний баг"-ийн даргаар тус тус баталгаажуулав.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлсэн байдал:

Үнэлэгдсэн албан хаагчийн тоо, хувь	
2025 оны хагас жил	2026 оны хагас жил
86 буюу 98.6 хувь	89 буюу 98.2 хувь

Газрын албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг мэдээлэх хуудсаар <http://shilen.gov.mn/> цахим хуудаст Мэдээллийн технологийн хэлтэстэй хамтран Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал талбарт нээлттэй байршуулсан.

3.5.Өргөдөл гомдол, албан бичиг шийдвэрлэлт, иргэд, аж ахуйн нэгж газруудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Албан бичгийн шийдвэрлэлт: Манай газарт тайлант хугацаанд (ub.erp систем, smart office систем) 2299 албан бичиг ирсэн бөгөөд хариутай 606 хариугүй 1693 байна. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 3, шийдвэрлээгүй албан бичиг байхгүй албан бичгийн шийдвэрлэлт 99,7 хувьтай байна. Албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 6,6 байна.



График 3.3-4



График 3.3-5

Ирсэн болон явуулсан албан бичгийг хэлтэс тус бүрээр өмнө оны мөн үетэй харьцуулвал:



График 3.3-6



График 3.3-7

Тайлант хугацаанд 3063 албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулснаас хариутай албан бичиг 1532 хариугүй 1531 байна. (Хүснэгтэд хэлтэс тус бүрээр харуулав)



График 3.3-8

2025 оны хэвлэмэл хуудасны захиалга, ашиглалт, зарцуулалтыг бүртгэлжүүлж, хяналт тавьж, Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Хэвлэмэл хуудас хүчингүй болгох, устгах тухай" А/05 дугаар тушаалаар 2025 оны хүчингүй болсон хэвлэмэл хуудсыг зургаар баталгаажуулан устгалд оруулсан. Үүнд:

- ✓ Хэвлэлийн болон хэл бичгийн дүрэм, утга агуулга, найруулгын алдаатай, үсэг давхардсан, хэвлэх төхөөрөмжийн хорны тохиргоо алдагдсан, дууссан гэх мэт шалтгаанаар 27 хэвлэмэл хуудсыг хүчингүй болгосон.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт: Тайлант хугацаанд Erp.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын программд нийт 104 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Иргэнээс 100, албан хаагчаас 4 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба хугацаандаа шийдвэрлэгдсэн 85 буюу 81 хувь, судлагдаж байгаа 19 буюу 18 хувь өргөдөл, гомдол байна.

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад 9 зөрчил бүртгэгдсэн. Үүнд:

- ✓ Явцын тэмдэглэл хөтлөөгүй 1
- ✓ Өдөрт нь багтаан хүлээн аваагүй 8

2025, 2026 оны хагас жилийн байдлаар харьцуулбал:



График 3.3-9

Өргөдөл, гомдлын хүлээн авсан хэлбэр (2026.01.02-2026.06.19)



График 3.3-10

3.6.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл

Газрын даргын Ажлын хэсэг байгуулах тухай 27 тушаал батлагдсан. Үүнд:

1."Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Архивд хадгалагдаж байгаа 2022-2024 онуудын "Техникийн зөвлөлийн хурал"-ын тэмдэглэлд холбогдох баримт бичгүүдийг албан хэрэг хөтлөлтийн шатанд зохион бүрдүүлж Архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн баримт бичгийн бүрдэлд хийсэн хяналт шалгалтын тайлангийн хүрээнд гарсан дүгнэлт, зөвлөмжийг нягталж ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/01,

2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/47 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Баянзүрх дүүргийн 2, 19, 24 дүгээр хороодод "Хороо, дүүргийн орчныг сайжруулах жишиг гудамж тохижилт"-ын ажил хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/02,

3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/1028 дугаар захирамж, 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн НХААГ20250101696 дугаартай ажлын гэрээний дагуу ДЦС-2, ДЦС-4 ТӨХК-уудын үнс зайлуулах системийн шугам хоолой шинэчлэл, өргөтгөлийн ажлыг ашиглалтад хүлээн авах Техникийн комиссын бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/03,

4.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/1150 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан жагсаалтын 5 дугаар төсөл, арга хэмжээ Хан-Уул дүүргийн 25 дугаар хорооны 640 суудалтай сургуулийн барилгын шугам зөөж шилжүүлэх

ажлыг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/04,

5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/107 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хүүхдийн хоол үйлдвэрлэлийн угаагч, ариутгагч тоног төхөөрөмж Багц-2 Анги танхимын зориулалттай аяга таваг угаагч, ариутгагч худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/14,

6.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/20 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 5 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Багц-2 камер, дуран, зургийн аппарат, энгэрийн камер худалдан авах ажлын гэрээ) хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/17,

7.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/20 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 5 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Багц-6 багаж, гар хэрэгсэл худалдан авах ажлын гэрээ) хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/18,

8.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/20 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 5 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Багц-8 хувцас, иж бүрдэл худалдан авах ажлын гэрээ) хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/19,

9.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн "Нийслэлийн 2025-2026 оны өвөлжилтийн хугацаанд хүндэрч болзошгүй ажлын санхүүжилт, цаашид авах арга хэмжээний тухай" А/1144 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 11 дүгээрт заасан Ерөнхий боловсролын 121 дүгээр сургуулийн дотуур байрны эргэлтийн насос, зуух шинэчлэх худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/24,

10.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/107 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаарт заасан Хүүхдийн хоол үйлдвэрлэлийн угаагч, ариутгагч тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц-1 Сургууль, цэцэрлэгийн гал тогооны зориулалттай аяга таваг угаагч, ариутгагч худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/28,

11.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/1794 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 29 дүгээрт заасан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хороодод шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 5-17, 23, 25, 28-31, 37, 39, 42, 43 дугаар хороод) Зөөврийн компьютер хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/36,

12.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Захиалагчийн хяналт тавих тухай” А/338 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 4 дүгээрт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Багц:2 Баянзүрх дүүрэг, 35 дугаар хороо, Нийгмийн хамгааллын тусгай төвийн өргөтгөл буюу сургалт хүмүүжлийн төвийн байрны гал тогооны тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/38,

13.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/20 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 5 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Улаанбаатар хот, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/40,

14.Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны А/570 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 3 дугаар ажил, БЗДХААА/202308126-1 дугаартай ажлын гэрээний дагуу Баянзүрх дүүргийн камержуулалтын ажлыг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/41,

15.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1338 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан жагсаалтын 3 дугаар төсөл, арга хэмжээ Зоогийн газрын хооллох заалны тавилга, эд хогшил худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/52,

16.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1792 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан жагсаалтын 25 дугаарт заасан Сонгинохайрхан дүүрэгт байрлах 240 ортой цэцэрлэгийн барилга худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/53,

17.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/356 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэмт хэрэг, гамшгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/55,

18.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/356 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэмт хэрэг, гамшгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/56,

19.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/347 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 6 дугаарт заасан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бараа материал худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/59,

20.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1783 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 7 дугаарт

заасан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэрлэн чигмэглэл худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/60,

21.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/1794 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 33 дугаарт заасан 40 хүүхдийн хүчин чадалтай цахим танхим (Сүхбаатар дүүргийн 2, 9, 11, 14, 18 дугаар хороо) хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/63,

22.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/347 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 5 дугаарт заасан Налайх дүүргийн 3 дугаар хороонд байрлах 152 дугаар цэцэрлэгийн дотоод сантехникийн шугам засварлахад шаардлагатай бараа материал худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/64,

23.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/347 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 8 дугаарт заасан Налайх дүүргийн 8 дугаар хороо, МТ колонкийн уулзварт бичил цэцэрлэг байгуулахад шаардлагатай мод, бут, хашаа, хайс хийх материал худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/65,

24.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/347 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 3 дугаарт заасан Автобусны буудлын тохижилт хийхэд шаардлагатай бараа материал худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/66,

25.Барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/68,

26.Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/99 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хан-Уул дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн камержуулалтын ажлын гэрээний дагуу 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороодод камер суурилуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/69,

27.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/347 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 7 дугаарт заасан Гэр хорооллын худгуудыг түшиглэн нийтийн эзэмшлийн талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай мод, бут, сөөг, хашаа, хайс хийх материал худалдан авах (20 байршилд) Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/75.

Үнэлгээний хороо байгуулах тухай 12 тушаал батлагдсан. Үүнд:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/126 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/07,

2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/202 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/16,

3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/298 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/26,

4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/337 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/29,

5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/340 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/30,

6. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/356 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2 дугаарт заасан ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/31,

7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/390 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд Чингэлтэй дүүрэгт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/34,

8. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/391 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/35,

9. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/531 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/42,

10. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/536 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/43,

11. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/540 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг мөн өдрийн А/44,

12. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/337 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/49.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг хангуулан **shilen.gov.mn** шил ажиллагаа сайтад дараах мэдээллийг 1 дүгээр улирлын байдлаар байршуулав. Үүнд:

- ✓ Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд
- ✓ Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд
- ✓ Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд
- ✓ Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдлын хүрээнд
- ✓ Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд хамаарал бүхий 45 мэдээлэл.

Хагас жилийн байдлаар 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тайлагнахаар ажиллаж байна.

Газрын **invest.ub.gov.mn** цахим хуудаст үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, хэрэгжүүлж буй хууль, эрх зүй, дүрэм журам, санхүүжилт, хөрөнгө оруулалтын мэдээлэл, шилэн данс, үйл ажиллагааны тайлан зэрэг 132 мэдээллийг тухай бүр тайлагнан ажиллав.

4.2. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Газрын үйл ажиллагааг сурталчлах, захиалагчийн хяналт тавьж хэрэгжүүлэн ажиллаж байгаа төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын мэдээ, тайланг газрын албан ёсны цахим хуудас (фейсбүүк хуудас, веб хуудас, твитер)-т нийтлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах, олон нийтэд мэдээлэх, газрын нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.



Зураг 4.2-1

Газрын вэб хуудаст 58, фейсбүүк хуудаст 73, твитер хуудаст 50 мэдээлэл тус тус нийтлэв.

Тайлант хугацаанд манай газраас хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын мэдээ, мэдээлэл бэлтгэх чиглэлээр нийт 81 мэдээ нийтлэв.

2025, 2026 оны хагас жилийн харьцуулсан байдал



График 4.2-1

✓ Бүтээн байгуулалтийн зурган мэдээ бэлтгэх чиглэлээр-50



Зураг 4.2-2

✓ Газрын дотоод үйл ажиллагааны мэдээ бэлтгэх чиглэлээр-8



Зураг 4.2-3

✓ Видео, reel, story мэдээ бэлтгэх чиглэлээр-15




Зураг 4.2-4

✓ Постер мэдээ бэлтгэх хүрээнд-8



Зураг 4.2-5

✓ Англи хэл дээр мэдээ бэлтгэх хүрээнд-11



Зураг 4.2-6

✓ Үндэсний бичиг дээр мэдээ бэлтгэх хүрээнд-22



Зураг 4.2-7

Систем хөгжүүлэлтийн чиглэлээр:

Тайлант хугацаанд газрын invest.ub.gov.mn мэдээллийн цахим системд 99 мэдээлэл нийтлэв.




Зураг 4.2-6

Өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал



График 4.2-2

Investpro.ub.gov.mn дотоод бүртгэл, мэдээллийн системд 16 удаа засвар, тохиргоог тухай бүр хийж ажиллав.



Зураг 4.2-6

4.3.Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн данс:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган 27 мэдээ, мэдээллийг шилэн дансны цахим <http://shilendans.gov.mn/> сайтад тухай бүр тайлагнасан. Үүнд:

Төсөв гүйцэтгэл: Газрын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ;

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт: Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

Бусад: Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэргийг мэдээлэв. Мөн газрын цахим <http://invest.ub.gov.mn/> сайт, мэдээллийн самбарт санхүүгийн байдлын тайлан, холбогдох мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг тухай бүр байршуулан нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллав. 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 5 сая төгрөгөөс дээш орлогын 202 ажил гүйлгээний 18,2 тэрбум төгрөг, зардлын 200 ажил гүйлгээний 23.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн мэдээг сар бүр хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn сайтад бүртгэж байршуулсан.

4.4. Санхүүгийн тайлан мэдээний чиглэлээр

Газрын санхүүгийн үйл ажиллагаагаа Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөн явуулдаг.

Хүснэгт 4.4-1 Санхүүгийн товчоо урьдчилсан байдлаар (төгрөгөөр)

Балансын зүйл	Үлдэгдэл	
	1 сарын 1	06 сарын 19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	65,873,760.02	58,210,175.86
Дансны авлага	423,174.57	645,741.75
Татвар, НДШ-ийн авлага	10,630.80	0.00
Бусад авлага	4,398,835.82	4,407,946.13
Бараа материал	5,400.78	5,443.63
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,524.47	4,885.59
Бусад эргэлтийн хөрөнгө	856,459,820.38	856,459,820.38
Эргэлтийн хөрөнгийн дүн	927,177,146.82	919,734,013.33
Үндсэн хөрөнгө	545,171.91	492,035.80
Биет бус хөрөнгө	20,693.33	18,486.67
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	565,865.24	510,522.47
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	927,743,012.07	920,244,535.80
Дансны өглөг	2,004,261.93	1,993,713.17
Цалингийн өглөг	0.00	0.00
Татварын өр	99,776.41	0.00
Урьдчилж орсон орлого	2,196,469.44	0.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,300,507.78	1,993,713.17
Нөөц /өр төлбөр/	59,407,593.55	54,011,214.43
Урт хугацаат өр төлбөрийн дүн	59,407,593.55	54,011,214.43
Өр төлбөрийн нийт дүн	63,708,101.33	56,004,927.61
Өмч: - төрийн	78,198.42	78,198.42
Хүримтлагдсан ашиг	863,956,712.31	864,161,409.77
Тайлангийн үеийн ашиг	0.00	204,697.46
Өмнөх үеийн ашиг	863,956,712.31	863,956,712.31
Эздийн өмчийн дүн	864,034,910.73	864,239,608.19
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	927,743,012.07	920,244,535.80

Нийт хөрөнгийн 99 хувийг эргэлтийн хөрөнгө, 13 хувийг өр төлбөр эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн 92 хувийг бусад эргэлтийн хөрөнгө буюу дуусаагүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилт эзэлж байна. Мөн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн харилцах дансанд 54,004,927.61 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 4.4-2 2026 оны хагас жилийн байдлаар орлого үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

№		Үзүүлэлт	2026 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл 2026.06.19
1	Орлого	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаас олгох орлого	6 347 300.00	3 745 120.00
		Бусад эх үүсвэрээс орлох орлого /Үйл ажиллагааны менежмент/ гадны төсөл хөтөлбөр	6 074 124.00	5 538.11
		Нийт орлого	12,421,424.00	3,750,658.11
2	Зардал	ББӨрлөг	607 072.00	82 439.52
		Цалин	9 060 366.37	2 841 153.13
		НД ЭМДШ 12.5%	1 132 545.80	354 351.66
		Засвар үйлчилгээ	37 200.00	210.00
		Сэлбэг засвар	40 857.70	5 281.00
		Түрээс ашиглалт	205 200.00	74 924.00
		Элэгдэл	100 000.00	55 342.00
		Тээвэр, даатгал	35 173.80	2 833.67
		Шуудан холбоо	27 624.00	6 081.67
		Шатахуун	56 902.75	10 638.00
		Сургалт	131 000.00	33 843.00
		Хангамжийн материал	35 865.10	7 225.00
		Хөдөлмөр хамгаалал	7 000.00	1 617.00
		Бичиг хэрэг	54 851.70	9 615.00
		Бусад	120 240.00	2 061.00
Үйл ажиллагааны бус	435 250.00	58 345.00		
	Нийт зардал	12,087,149.22	3,545,960.65	
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	334 274.78	204 697.46	
4	Татварын зардал	33 427.48		
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагд)	300,847.31	204,697.46	
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.97	0.95	

Техник хяналтын орлого 3,750,658.11 мянган төгрөг, 3,545,960.65 мянган төгрөгийн зардлын 90 хувь буюу 3,195,504.79 мянган төгрөгийг цалин, НДШ-ийн зардал, үйл ажиллагааны зардал нь 10 хувь буюу 350,455.86 мянган төгрөг байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1 Дотоод ажлын чиглэлээр (зохион байгуулсан ажил)

"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-аас захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэн, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн "Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий жишиг спорт заал"-ны бүтээн байгуулалтыг танилцуулах нээлтийн арга хэмжээний хөтөлбөрийг Газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав. 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 13.00-14.00 цагт Нийслэл, Дүүргийн удирдлага, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар болон тус сургуулийн багш, сурагч, эцэг, эх, хамтран ажилладаг байгууллага, иргэд, олон нийтэд танилцуулж, нээлтийн үйл ажиллагааг тус сургуультай хамтран зохион байгуулав.



Зураг 5.1-1

Газрын "Ёс зүйн дэд хороо"-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 12-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, хагас жилийн биелэлт (79,4 хувь)-ийг нэгтгэж, Захиргааны хэлтсийн даргаар баталгаажуулав. Төлөвлөгөөний хэрэгжилт Төлөвлөгөөний дагуу ёс зүйн зөрчил, гомдол, мэдээллийг хүлээж авах QR код бүхий зурагт холбоос, саналын "Хайрцаг"-ийг газрын мэдээллийн самбарт байршуулан ажилтан, албан хаагч болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдээлэл хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна.



Зураг 5.1-2

Монгол Улсын Засгийн газар, "Жөндөрийн үндэсний хороо"-оос зохион байгуулж буй "Харилцан хүндэтгэе" 1 сарын аяны төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Захиргааны хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. "Эерэг хандлага-Эерэг орчин" угтах өдөрлөгийг хэлтэс тус бүр дотоод хуваарийн дагуу зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулав.



Зураг 5.1-3

2. Аяны хүрээнд газрын дотоод сүлжээ (teams)-ээр "Эерэг үг-Эерэг өдөр" постерийг 5 удаа байршуулав.



Зураг 5.1-4

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлах тухай" А/02 дугаар тушаалын дагуу 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 10:00-11:30 цагийн хооронд Автобусны буудлын эцсүүд (Яармагийн 1, 2, 3-р буудал, Эмнэлэгийн буудал)-ийн урд болон хойд хэсгийн дэргэдэх түүвэр хог хаягдлыг 17 албан хаагч цэвэрлэн, нийт 8 шуудай хуурай хог хаягдлыг уутлаж, тээвэрлэхээр бэлтгэв.



Зураг 5.1-5

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэх тухай 58 дугаар зарлиг, 2025 оны "Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 44 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан 2026 оны хаврын "Мод тарих арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг ханган, "Байгальд өгсөн бүхэн буцаж ирдэг" уриан дор 2026 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Налайх дүүргийн "Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн"-д нийт 20 ширхэг Миндаль модыг, 11 албан хаагч тарьж усалгаа хийв. Мод тарьсан тухай мэдээллийг бэлтгэн, 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Газрын цахим сүлжээ <https://invest.ub.gov.mn/> болон ERP системд байршуулав.



Зураг 5.1-6

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн "Удирдамж хүргүүлэх тухай" 01/1172 дугаар албан бичгийн дагуу тус албаны 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн "Хотын аж ахуйг эрчимжүүлэх 21 хоногийн аян зохион байгуулах тухай" удирдамж болон Нийслэлийн Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн "Хотын аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврын дагуу "Хотын аж ахуйн ажлыг эрчимжүүлэх 21 хоногийн нөлөөллийн аян"-д нэгдэж, аяны хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

	Хотын аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Хотын аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
--	--	--

Зураг 5.1-7

Удирдамжид заасны дагуу аяны явцын үр дүнгийн тайланг 7 хоног бүрийн Пүрэв гарагт буюу 2026 оны 06 дугаар сарын 18, 25, 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн дэд бүтцийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

Соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:

Газрын алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, "Соёл, спорт хамтлаг"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд "Гар бөмбөг", "Ширээний теннис"-ийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн спорт зааланд "Соёл, спорт хамтлаг"-ийн ажлын хэсэг зохион байгуулав. Тэмцээнд 5 багийн нийт 90 тамирчин оролцож, мэргэжлийн шүүгчид шүүн явуулав.



Зураг 5.1-6

Газрын "Боулинг"-ийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах удирдамж, хөтөлбөр боловсруулан, газрын даргаар 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдөр батлуулж, 03 дугаар сарын 06-ны өдөр Мишээл спорт зааланд зохион байгуулж, 5 багийн нийт 88 албан хаагч оролцов. Тэмцээнийг "Боулинг"-ийн холбооны мэргэжлийн шүүгчид шүүн явуулав.



Зураг 5.1-7

Газрын "Сагсан бөмбөг", "Дартс"-ын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах удирдамж, хөтөлбөр боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр батлуулж, 03 дугаар сарын 21-ний өдөр Тайгер спорт зааланд зохион байгуулав. 5 багийн нийт 82 тамирчин оролцов. Тэмцээнийг "Сагсан бөмбөг"-ийн холбооны мэргэжлийн шүүгчид шүүн явуулав.



Зураг 5.1-8

Газраас зохион байгуулсан нийт 5 төрөлт тэмцээнд давхардсан тоогоор 260 албан хаагч оролцов.

Мөн Монголын Барилгын зураг төсөл зохиогчдын холбооноос 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан "Спорт наадам" арга хэмжээнд манай газраас Сагсан бөмбөгийн 1 баг, Гар бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 баг буюу нийт 18 тамирчин амжилттай оролцсон.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/396 дугаар захирамжийн хүрээнд "Улаанбаатар марафон 2026" Олон улсын гүйлтийн тэмцээн 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж, манай газраас 5 км-т 9, 10 км-т 11, 21 км-т 7, нийт 27 албан хаагч амжилттай оролцов.



Зураг 5.1-9

Хагас жилийн байдлаар нийт 7 төрлийн спортын тэмцээн уралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 305 албан хаагч хамрагдав.


5.2. Сургалтын чиглэлээр

Газрын 2026 оны "Сургалтын төлөвлөгөө"-г боловсруулж, 03 дугаар сарын 11-ний өдрийн "Сургалтын төлөвлөгөө батлуулах тухай" А/27 дугаар тушаалын хавсралтаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 45 удаагийн сургалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор 1166 албан хаагч хамрагдав. Үүнээс:

- ✓ Гадаад томилолт, сургалт – 2 удаа, 13 албан хаагч
- ✓ Дотоод сургалт – 17 удаа, 1011 албан хаагч
- ✓ Мэргэшүүлэх сургалт – 23 удаа, 139 албан хаагч
- ✓ Зөвлөгөөн, семинар, хэлэлцүүлэг – 3 удаа, 3 албан хаагч

2025-2026 оны 06 дугаар сарын байдлаар сарын байдлаар сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийн хамрагдалтын харьцуулсан үр дүн



✓ 2026 оны 06 дугаар сарын 19-ний байдлаар нийт амрагдсан албан хаагчийн тоо 2025 оны мөн үеэс 511-аар (77.9%) нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд Чой.Лувсанжавын нэрэмжит "Хэл Иргэншлийн Эрдмийн Хүрээлэн"-тэй хамтран Монгол бичгийн "Дунд" шатны сургалтыг нийт 11 удаа зохион байгуулан, давхардсан тоогоор 727 албан хаагч хамрагдаж, 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 89 албан хаагчид гэрчилгээ гардуулав.



Зураг 5.2-1

5.3. Гэрээ эрх зүйн чиглэлээр

2026 оны хагас жилийн байдлаар барилга угсралтын ажлын гэрээ, зохиогчийн хяналтын гэрээ, тоног төхөөрөмжийн ажлын гэрээ, зөвлөх үйлчилгээний гэрээ, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх гэрээ, гэрээний сунгалтууд, бусад гэрээ зэрэг нийт 705 гэрээг хянан баталгаажуулсан. Хянан баталгаажуулсан гэрээг ангилбал:

- ✓ Барилга угсралтын ажлын гэрээ – 142
- ✓ Бараа тоног төхөөрөмжийн гэрээ – 34
- ✓ Зохиогчийн хяналтын гэрээ – 95
- ✓ Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ – 18
- ✓ Барилга угсралтын ажлын хугацаа сунгах гэрээ -262
- ✓ Барилга угсралтын ажлын нэмэлт гэрээ – 3
- ✓ Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ сунгалт – 32
- ✓ Захиалагчийн техник хяналтын гэрээ- 6
- ✓ Барьцаа чөлөөлөх гэрээ дүгнэсэн протокол – 105
- ✓ Бусад гэрээ – 3
- ✓ Гэрээ цуцлах гэрээ дүгнэсэн протокол – 5

2025, 2026 оны хагас жилийн гэрээний мэдээг хүснэгтээр харьцуулбал:



График 5.3-1

Хууль, эрх зүйн чиглэлээр:

2026 оны хагас жилийн байдлаар Иргэний хэргийн шүүхийн шатанд 7 иргэний хэрэг, Захиргааны хэргийн шүүхийн шатанд 3 захиргааны хэрэг, нийт 10 хэрэг

маргаан байна. Үүнээс: Иргэний хэргийн шүүхийн шатанд хянагдаж байгаа 7 иргэний хэргээс Улсын дээд шүүхэд 3, Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд хянагдаж байгаа 4 иргэний хэрэг байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой 22 удаа шүүх хуралдаанд оролцсон байна.

2025, 2026 оны хагас жилийн шүүхийн мэдээг хүснэгтээр харьцуулбал:





График 5.3-2

Тайлант хугацаанд газрын даргын 2026 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан "Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх журам"-ын хүрээнд нийт 739 баримт бичиг хүлээн авч, гүйцэтгэгч байгууллагад үйлчилгээ үзүүлэв. Үүнд:

- ✓ Барилга угсралтын ажлын гүйцэтгэл (санхүүжилт)-267
- ✓ Барилгын ажлын хугацаа сунгах нэмэлт гэрээ-276
- ✓ Барьцаа хөрөнгө чөлөөлөх -88
- ✓ Барилгын ажлын гэрээнд өөрчлөлт оруулах нэмэлт гэрээ-1
- ✓ Зураг төслийн ажлын гүйцэтгэл (санхүүжилт)-14
- ✓ Зураг төслийн ажлын хугацаа сунгах нэмэлт гэрээ-40
- ✓ Зохиогчийн хяналтын гэрээ-35
- ✓ Тоног төхөөрөмж, худалдан авах ажлын гүйцэтгэл-2
- ✓ Тоног төхөөрөмж, худалдан авах гэрээ сунгалт-16

2025, 2026 оны хагас жилийн байдлаар харьцуулсан тоон мэдээ:



2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар Улсын төсөв, нийслэлийн төсөв, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний 243

удаагийн (давхардсан тоогоор) явцын болон эцсийн гүйцэтгэлийн бичиг баримтыг хянасан байна. Үүнийг ажлын төрлөөр авч үзвэл:

Хүснэгт 5.3.-1 Хянасан гүйцэтгэлийг төрлөөр харьцуулбал:

Д/д	Ажлын төрөл	2025 он (хагас жил)	2026 он (хагас жил)
1	Барилга угсралтын ажил	103	76
2	Инженерийн шугам сүлжээний ажил	10	44
3	Зөвлөх үйлчилгээний ажил	3	12
4	Тохижилтын ажил	29	20
4	Засварын ажил	44	70
6	Барилга худалдан авах, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил	12	21
7	Зохиогчийн хяналтын гүйцэтгэл	95	0
НИЙТ		114	243

5.4.Архивын чиглэлээр

"Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт" батлуулах ажлын хүрээнд:

Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаал "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт болон салбарын жагсаалт"-ыг удирдлага болгон газрын 2026 онд хөтлөгдөх "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг боловсруулж, хэлтсүүдээс 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр саналын хуудсаар санал авч нэгтгэн, 2026 оны 05 дугаар сарын 02-ны өдөр газрын дэргэдэх БНШК-ын 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн, 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр газрын даргаар батлуулав.

1 дүгээр улиралд архив хүлээн авах ажлын хүрээнд:

Газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн баталсан "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу 2025 онд хөтлөгдөж дууссан баримт бичгүүдийг ангилан төрөлжүүлж, архивын нэгж үүсгэн Газрын архивд бүрэн бүрдэлтэй хүлээн авахаар нийт ажилтан, албан хаагчдад шинэчлэгдэн батлагдсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын холбогдох заалтууд мөн Баримт бичгийн стандартаар сургалт зохион байгуулж мэдээлэл өгч ажиллав.



Хадгаламжийн нэгж бүрдүүлэх

- Хадгаламжийн нэгжид албан ёсны бүрэн бүрдэл бүхий зөвхөн нэг хувь эх баримт байх бөгөөд байнга хадгалах хадгаламжийн нэгж нь **250 хуртлал** хуудастай байх. Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн хуудасны тоо **250-аас хэтрэсэн** тохиолдолд тэдгээрийг хэд хэдэн **богь, болж, боь** бүрийн **хуудсыг 1-ээс эхэлж** дугаарлана.
- Тус хадгалах хадгаламжийн нэгж нь **40 мм** хуртлал зугаантай байна.

Зураг 5.4-1

Хэлтсүүдээс 1 дүгээр улиралд багтаан архив хүлээн авахаар "2026 онд архивд баримт хүлээн авах дотоод хуваарь" боловсруулан 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Газрын даргаар батлуулан, хэлтэс тус бүрт танилцуулав.

Зураг 5.4-2

2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн батлагдсан "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт", 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн батлагдсан "Архивд баримт хүлээн авах дотоод хуваарь"-ийн дагуу газрын архивд дараах байнга, түр, 70 жил хадгалах баримтуудаар нөхөн бүрдүүлэлт хийв. Үүнд:

1. байнга хадгалах-600 хн,
2. түр хадгалах-344 хн,
3. 70 жил хадгалах-6 хн,
4. тусгай төрөл-11 хн, нийт 961 хадгаламжийн нэгжийг цаасан суурьтай, бүрдэл бүрэн, нягтлан шалгаж хүлээн авав. Архивд хүлээн авсан баримтаас дараах баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэн авсан. Үүнд:
 - ✓ Тендер гүйцэтгэлийн байнга хадгалах 461 хн,
 - ✓ Түр хадгалах 130 хн,
 - ✓ 70 жил хадгалах 4 хн,
 - ✓ Удирдлагын байнга хадгалах 61,
 - ✓ Архивын байнга хадгалах 9 хн, нийт 665 хадгаламжийн нэгжийг цахимжуулав.

Дотоодод нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримтын тоон мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,93 хувиар буурсан үзүүлэлттэй харагдаж байна.




График 5.4-1

Архивын баримт цэгцлэх ажлын хүрээнд:

"Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-д байнга хадгалахаар заасан тендер гүйцэтгэлийн баримтын эрэлт хайлтыг хурдан шуурхай болгох үндсэн дээр 2022 оны 318 хадгаламжийн нэгжийг задлан сканнердаж pdf файл хэлбэрээр хадгалан буцаан үдэж цахим архив үүсгэв.

2025 онд хөтлөгдөж дуусан архивд хүлээн авсан 425 хадгаламжийн нүүр бичилт хийж, шифр тэмдэг дарж ажиллав.



Зураг 5.4-3

"Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн зөвлөмж"-ийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн Архивын газраас ирүүлсэн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Улсын үзлэгийн зөвлөмж хүргүүлэх тухай" 01/110 дугаар албан бичиг, Нийслэлийн засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт,

ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн дүнгийн тухай А/1819 дүгээр захирамж, Нийслэлийн Архивын газрын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн "Хэрэгжилтийг хангуулах тухай" 09/30 дугаар Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийн дагуу Газрын Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдөр А/23 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган, биелэлтийг Нийслэлийн Архивын газарт 1 дүгээр улирлын байдлаар 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1543 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Хагас жилийн байдлаар 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон хүргүүлэхээр холбогдох мэргэжилтнүүдээс мэдээллийг авч нэгтгэж байна.



Зураг 5.4-4

Архиваас түр олгосон баримт олгох ажлын хүрээнд:

Газрын архивд хадгалагдаж байгаа байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжээс нийт 181 хадгаламжийн нэгжийг холбогдох журмын хүрээнд "Түр олгосон баримтын бүртгэл" хөтлөн эрх бүхий байгууллага болон газрын инженер, мэргэжилтэнүүдийн хүсэлтээр тухай бүр олгов.

Түр олгосон баримтын тоон мэдээг 2025 оны тоон мэдээтэй харьцуулвал 1,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна:



График 5.4-2

Хуулбар үнэн, хуулбар хувь дарах ажлын хүрээнд:

Эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, газрын инженер, мэргэжилтнүүдээс гаргасан хүсэлтийн дагуу:

- газрын архивд хадгалагдаж байгаа архивын баримтаас 525 хуудас баримт бичгийг хуулбарлан хуулбар үнэн тэмдэг,
- газрын албан хэрэг хөтлөлтийн шатанд хэрэгжиж байгаа 133 хуудас баримт бичгээс хуулбарлан хуулбар хувь тэмдэг дарж бүртгэл хөтлөн ажиллав.

Хуулбар үнэн тэмдэг дарсан үзүүлэлтийг 2025 оны тоон мэдээтэй харьцуулвал 2026 онд 83,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хуулбар үнэн олгосон тоон мэдээ



График 5.4-3

5.5. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах чиглэлээр

2026 оны хагас жилийн байдлаар 66 төсөл, арга хэмжээнд улсын комисс ажиллуулан, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөв. Мөн 55 төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнд:

Боловсрол, эрүүл мэндийн салбарт:

1.Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил дуусаж, улсын комисс хүлээн авлаа.

Тус сургуулийн барилга нь нийт 5869 м.кв талбай бүхий 39.9м х 16.0м, 22.5м х 15.8м, 33.9м х 16.0м хэмжээтэй 3 блок барилга бөгөөд 16 хичээлийн анги танхимууд, номын сан, багш нарын өрөө, эмчийн өрөө, гал тогоо болон бусад зориулалтын өрөөнүүдтэйгээр төлөвлөгдөн баригдсан. Спорт заалны 2 барилга нь тэнхлэгээрээ 30.0м х 18.0м хэмжээтэй, 18.0м х12.0м хэмжээтэй.



Зураг 5.5-1

2.Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн усан бассейн бүхий спорт заалны барилга угсралтын ажил дуусаж, улсын комисс хүлээн авлаа.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан энэхүү барилга нь тэнхлэгээрээ 34м х 36м хэмжээтэй, нийт 2448 м.кв талбай бүхий 2 давхар барилга бөгөөд нэгдүгээр давхартаа олон улсын стандартад нийцсэн 25м х 8.8м хэмжээтэй усан бассейн, багшийн болон эмчийн өрөө, эрэгтэй, эмэгтэй хувцас солих өрөө, шүршүүр, ариун цэврийн өрөө, техникийн зориулалтын өрөөнүүдийг иж бүрнээр нь төлөвлөж гүйцэтгэв.

Хоёрдугаар давхрын спорт заал нь олон улсын стандартад нийцсэн шал, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Ингэснээр сурагчид стандартад нийцсэн, тохилог орчинд суралцах боломж бүрдэж байна.

Усан бассейны усыг зориулалтын шүүлтүүрийн систем болон робот цэвэрлэгч ашиглан тогтмол цэвэрлэж, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллуулж байгаа нь онцлог юм.




Зураг 5.5-2

3.Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороонд 200 ортой цэцэрлэгийн барилгын ажил дууслаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан тус цэцэрлэг нь 39 м х 25 м хэмжээтэй, зоорьтой 2 давхар барилга юм. Дотор зохион байгуулалтын хувьд цэцэрлэгийн анги, бүлгийн өрөөнүүд, багш нарын өрөө, хувцас солих өрөө, гал тогоо, ариун цэврийн өрөө болон бусад өрөө тасалгаануудыг төлөвлөн гүйцэтгэсэн.

Мөн гадна тохижилтын хүрээнд хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам, гадна гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 5.5-3

4.Баянзүрх дүүргийн 38 дугаар хороонд байрлах Баганат өргөө цогцолбор хотхонд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1500 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил гэрээт хугацаанаас өмнө дуусаж, улсын комисс хүлээн авлаа.

Тус сургуулийн барилга нь тэнхлэгээрээ 72.2 м х 30.0 м хэмжээтэй, нийт 8789.38 м.кв талбай бүхий зоорьтой, 4 давхар 3 блок барилга бөгөөд 45 хичээлийн танхимууд, 5 кабинет, номын сан, лаборатори, спорт заал -2, багш нарын өрөө, эмчийн өрөө, гал тогоо болон бусад зориулалтын өрөөнүүдтэйгээр төлөвлөгдөн баригдсан. Спорт заалны барилга нь тэнхлэгээрээ 39.0 м х 18.0 м хэмжээтэй бөгөөд 9.82 м х 4.5 м хэмжээтэй хүзүүвчээр сургуулийн үндсэн барилгатай холбогдсон. Мөн гадна тохижилтын ажлын хүрээнд явган хүний зам, авто зогсоол, гадна гэрэлтүүлэг, ногоон байгууламж болон бусад тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 5.5-4

5.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүргийн 3 дугаар хороонд хэрэгжүүлж буй 280 хүүхдийн хүчин чадалтай сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга угсралтын ажил 89 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Нийт 5000.0 м.кв талбайд хэрэгжиж буй тус барилга нь А, Б, В блок бүхий 17.4м х 24.0м, 18.0м х 24.0м, 17.4м х 24.0м хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар барилга юм.

Өнөөдрийн байдлаар дотор засал болон гадна тохижилтын ажил үргэлжилж байгаа бөгөөд 2026 ондоо багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.



Зураг 5.5-5

6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил өнөөдрийн байдлаар 84 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Тус сургуулийн барилга нь нийт 1992.0 м.кв талбайтай, зорь бүхий 4 блокоос бүрдэх бөгөөд блокуудын хэмжээг тэнхлэгээр нь авч үзвэл: А, Б блок нь 36.0м х 22.3м хэмжээтэй 2 давхар, В блок нь 19.86м х 29.6м хэмжээтэй 3 давхар, Г блок нь 42.0м х 16.6м болон 30.0м х 18.0м хэмжээтэй 1 давхар барилга байхаар тус тус төлөвлөгдсөн байна.



Зураг 5.5-6

Засвар, тохижилт:

1. Баянгол дүүргийн төв эмнэлэг болон ахмадын эмнэлгийн барилгын хэсэгчилсэн засварын ажил дууслаа.

Эмнэлгийн байгууллагын эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор Баянгол дүүргийн төв эмнэлгийн 1 дүгээр давхарт 120 мкв талбай болон Баянгол дүүргийн ахмадын эмнэлгийн 5 дугаар давхарт 410 мкв талбайг хамарсан хэсэгчилсэн засвар, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэлээ.

Засвар, шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн төвийн нэгдүгээр давхрын зүүн жигүүрт хэсэгчилсэн дотоод засал, сантехник, цахилгаан угсралтын ажлыг гүйцэтгэж, ахмадын эмнэлгийн тавдугаар давхарт өрөөнүүдийн хаалга, шал, хана, тааз угсралтын ажлууд болон хэсэгчилсэн сантехник, цахилгаан угсралтын ажлыг хийж дуусгав.



Зураг 5.5-7

2.Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн хэсэгчилсэн их засварын ажил дууслаа.

Эмнэлгийн байгууллагын эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн хоёрдугаар давхрын 432м.кв талбайд хэсэгчилсэн их засвар, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.Засвар, шинэчлэлийн хүрээнд өрөөнүүдийн хаалга, шал, хана, тааз, давхар дундын шатыг шинэчилж, ариун цэврийн өрөөнүүдэд шинэ тоноглол суурилуулан, дотор гэрэлтүүлэг болон бусад шаардлагатай засварын ажлуудыг хийж дуусгав.



Зураг 5.5-6

3.Налайх дүүргийн 5 дугаар хороонд Мал эмнэлгийн хяналт, ариутгал халдваргүйжүүлэлтийн байгууламж дуусаж, улсын комисс хүлээн авлаа.

Улаанбаатар хот руу нэвтрэх хүн, малын халдварт өвчнийг хязгаарлан ариутгаж, нийт ард иргэдийг болзошгүй өвчнөөс хамгаалах зорилгоор Налайх дүүргийн 5 дугаар хороонд Мал эмнэлгийн хяналт, ариутгал халдваргүйжүүлэлтийн байгууламж баригдлаа.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан энэхүү барилга нь 480.31 м.кв талбай бүхий 18.8м х 24м хэмжээтэй, зоорьгүй нэг давхар барилга юм. Тус байгууламж нь шалган нэвтрүүлэх барилга, агуулахын барилга, худгийн барилга, малын хашаа, малын саравч, гадна ус хангамж, ариутгал татуурга, цахилгаан хангамж, гадна тохижилтоос бүрдсэн зохион байгуулалттай юм.



Зураг 5.5-7

4.Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлах "Нийслэлийн Соёлын төв өргөө" ОНӨААТҮГ-ын Г блокт нийт 709 м.кв талбайг хамарсан хэсэгчилсэн их засварын ажил дуусан, улсын комисс хүлээн авлаа.

12 давхар тус барилгын засварын ажлын хүрээнд Г блокын үүдний хэсгийг бүрэн шинэчилж, 1-12 дугаар давхрын лифтний хэсэг болон гадна фасад, гадна довжооны засвар, хаягжилт шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэв.



Зураг 5.5-8

5.Налайх дүүргийн нэгдсэн эмнэлгийн засварын ажил дуусаж, улсын комисс хүлээн авлаа.

Эмнэлгийн байгууллагын эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор Налайх дүүргийн нэгдсэн эмнэлгийн 3 давхрын төрөх тасагт иж бүрэн засвар шинэчлэлтийн ажлууд хийгдлээ. Тус засвар, шинэчлэлтийн ажил нь нийт 1024.6 м.кв талбайг хамарсан бөгөөд хуучирсан болон эвдрэлд орсон хэсгүүдийг буулгаж, шал, хана, таазыг шинэчилж, цонх, хаалгануудыг шинээр суурилуулав.



Зураг 5.5-9

6.Нэгдсэн Үндэсний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын 17 дугаар бага хурлын бэлтгэл ажил үргэлжилж байна.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал манай улсад 2026 оны наймдугаар сарын 17-28-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн зүгээс түр байгууламж барих, авто зам, тохижилт болон шугам сүлжээний ажлыг хариуцан ажиллаж байна. Одоогийн байдлаар тус хурлын зохион байгуулалтад зориулж нийт 80 мянган ам метр талбайд дугуйн зам, явган хүний зам болон авто зогсоолын тохижилтын ажлыг гүйцэтгэж байна.



Зураг 5.5-10

5.6. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судалгааны чиглэлээр

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судалгааны чиглэлээр тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

1. 2026 онд Нийслэлийн хэмжээнд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийн сан үүсгэх, хэрэгжилтийг тогтмол гаргах
 - ✓ Нийслэлийн хэмжээнд 2026 онд Улсын төсөв, Нийслэлийн төсөв, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, Дүүргийн хөрөнгөөр хэрэгжих 1,560.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1148 ажлын мэдээллийн санг үүсгэж 30 үзүүлэлтээр 7 хоног бүр тогтмол явцын мэдээллээр 23 удаа шинэчилсэн.
 - ✓ 2026 онд шинээр хэрэгжиж буй 291 хөрөнгө оруулалтын ажлуудын байршлуудыг google earth программд холбосон байна
 - ✓ 2025-2026 онд он дамжин Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар хэрэгжих барилга угсралт, их засвар, зураг төсвийн 1,664.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 435 ажлын мэдээллийг загвар хүснэгтийн дагуу бэлтгэж, явцын мэдээллийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын барилга угсралт, их засвар, зураг төсвийн мэдээгээр 30 үзүүлэлтээр 7 хоног бүр тайлант хугацаанд нийт 23 удаа шинэчилсэн байна.
 - ✓ 2026 онд газарт эрх шилжин захиалагчийн хяналт тавьж хэрэгжүүлэх 228 ажлын захирамж гарснаас Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 164 ажлын зөвлөмж ирж гэрээ байгуулагдсан байна.
2. 2025 онд манай газраар хяналт тавьж хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын нийгэм эдийн засгийн үр өгөөжийн танилцуулга бэлтгэх
 - ✓ 2025 онд манай газраар захиалагчийн хяналт тавин хэрэгжүүлсэн 2,443.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 653 төсөл, арга хэмжээнээс 816.4 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 252 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна.
 - ✓ 2025 онд бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн товч танилцуулгыг Нийслэлийн 9 дүүргээр боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэхээр бэлтгэсэн.
3. 2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт
 - ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд манай газраар хяналт тавин бүрэн хэрэгжсэн 14,104.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 48 төсөл, арга хэмжээний хүснэгтэн мэдээлэл болон 2 хуудаст танилцуулгыг шинэчлэн боловсруулсан.
4. Нийслэлийн 9 дүүргийн ерөнхий мэдээлэл, хөрөнгө оруулалтын ажлын танилцуулга бэлтгэх

Дүүргийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлын судалгааны тоон мэдээлэлд үндэслэсэн дүн шинжилгээ хийх, 2025 онд манай газраар хяналт тавин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын мэдээлэл, 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийг салбар, ажлын төрлөөр гаргаж, дүүргийн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж танилцуулга бэлтгэв.
5. Нийслэлийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд шинээр санаачлан судалгаа хийх

Төлөвлөлт судалгааны хэлтэс Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой дараах төсөл, судалгааг шинээр санаачлан боловсруулж байна. Үүнд:

 - ✓ Бичил ой-Ногоон ирээдүй ногоон байгууламжийн судалгаа
 - ✓ Хан-Уул дүүргийн инженерийн шугам сүлжээний насжилт, хүртээмж, ачааллын судалгаа
 - ✓ Орон сууцны хорооллын авто зогсоолын шинэчлэл төсөл
 - ✓ Төрийн өмчийн сургуулиудын спорт заалны стандартын судалгаа
 - ✓ Сонгинохайрхан дүүргийн 37 дугаар хороо авто зогсоол, тохижилтын судалгаа хийх

- ✓ Тэтгэвэрийн дараах хөгжлийн төсөл
- ✓ 24 цагийн номын сангийн төсөл

6. Дүүргүүдийн хороодын хэрэгцээ шаардлагын судалгаа шинэчлэх

Нийслэлийн 9 дүүргийн 204 хороодын хөрөнгө оруулалтын хүртээмж, хэрэгцээ шаардлагын нарийвчилсан судалгааг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүн амын статистик үзүүлэлт, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн статистик мэдээлэл, 2025-2026 оны хичээлийн жилийн статистик мэдээлэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн мэдээлэл болон газрын барилга угсралт, их засвар, зураг төсвийн мэдээгээр шинэчилэв.

7. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагын тогтмол хийгддэг судалгааг шинэчлэн сайжруулах, бодит судалгаа хийх, холбогдох газруудтай хамтарч ажиллах (Боловсрол, эрүүл мэнд, угсармал орон сууцны судалгаа)

- ✓ Боловсролын салбарын судалгаа шинэчлэх

Боловсролын байгууллагуудын хүртээмж, хэрэгцээ шаардлагын судалгааг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн 171 сургууль, 325 цэцэрлэгийн мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүн амын статистик мэдээлэл, Боловсрол шинжлэх ухааны яамны 2025-2026 оны хичээлийн жилийн статистик мэдээлэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн мэдээллүүдийг үндэслэн 16 хавсралт, 15 үзүүлэлтээр шинэчилсэн.

- ✓ Нийтийн орон сууцны дээвэр, дулаан алдалтын судалгаа шинэчлэх

Улс, Нийслэлийн төсөв, Гадны зээл тусламжийн хөрөнгөөр газарт 2026 онд хэрэгжиж байгаа орон сууцны фасад засварын нийт 31 ажлын мэдээллийг бэлтгэж, Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа орон сууцны барилгуудын гадна фасад засварын ажлын явц, цаашид төлөвлөлтөд анхаарах асуудлын талаарх 7 хуудас танилцуулга бэлтгэсэн. Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 9 дүгээр шуурхай зөвлөгөөнд танилцуулагдсан.

- ✓ Эрүүл мэндийн салбарын судалгаа шинэчлэх

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмж, хэрэгцээ шаардлагын судалгааг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн газраас гаргасан 2025 оны 12 дугаар 31-ний статистик судалгаа, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн мэдээллийг үндэслэн шинэчилсэн.

8. 2027 оны Улсын төсвийн төсөлд санал бэлтгэх, хүргүүлэх

- ✓ Манай газарт Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт, их засварын 77 ажлын мэдээллийг 2027 оны төсвийн төсөлд хүргүүлэх загвар маягтын дагуу бэлтгэж, Барилга захиалагчийн хяналтын хэлтсээс шилжүүлэх саналын бөглөлтийг хийлгүүлж дуусгасан.
- ✓ 2027 оны Улсын төсвийн төсөлд тусгуулах шинэ, шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2109 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

5.7. Мэдээ, тайлангийн чиглэлээр

Газрын үйл ажиллагааны тайлангийн талаар:

- ✓ Газрын үйл ажиллагааны 14 хоногийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу нэгтгэн боловсруулж, сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт албан бичгээр нийт 8 удаа (2026.01.21-ний 01/285, 2026.02.04-ний 01/593, 2026.02.16-ны 01/804, 2026.03.10-ны 01/1110, 2026.04.14-ний 01/1750,

2026.04.28-ны 01/2051, 2026.05.12-ны 01/2293, 2026.05.25-ны өдрийн 04/2569 дугаарын албан бичгээр) хүргүүлэв.

- ✓ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн тайлан 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1/921 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.
- ✓ Газрын 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1558 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв. Хагас жилийн тайланг 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хүргүүлэхээр нэгтгэж байна.
- ✓ Газрын даргын иргэд, аж ахуй нэгжтэй хийсэн уулзалтын 2026 оны 1 дүгээр улирлын тайланг 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1511 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв. Хагас жилийн тайланг 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор холбогдох газарт хүргүүлэхээр нэгтгэж байна.
- ✓ Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/66 дугаар тушаалаар батлагдсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-ын дагуу 2026 оны 1 дүгээр улирлын тайлан, мэдээг 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/1425 дугаарын албан бичгээр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэв. Хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор холбогдох газарт хүргүүлэхээр нэгтгэж байна.
- ✓ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг 2026 онд хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтээс манай газарт хамааралтай төсөл, арга хэмжээний 6 ажлын биелэлт болон хэрэгжүүлэх арга хэмжээний 3 биелэлтийг загвар хүснэгтийн дагуу боловсруулан хагас жилийн байдлаар бэлтгэж 2025 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/2863 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэв.
- ✓ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 45 төлөөлөгчид манай газарт 2025-2026 онд он дамжин хэрэгжиж буй 285, 2026 онд шинээр хэрэгжиж буй 109 ажлын мэдээллийг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1988, 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/2345 дугаарын албан бичгээр тус тус хүргүүлэв.
- ✓ Манай газарт Улс, Нийслэлийн төсөв, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, Үнэт цаасны хөрөнгөөр 2026 онд хэрэгжиж байгаа нийт хөрөнгө оруулалтын 389 ажлын мэдээллийг загвар хүснэгтийн дагуу бэлтгэж дуусган хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлын мэдээллээр 9 дүүргийн 53 хуудас танилцуулга бэлтгэж 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1962 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв.
- ✓ Манай газарт Улс, Нийслэлийн төсөв, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, Үнэт цаасны хөрөнгөөр 2026 онд хэрэгжиж байгаа нийт 459 ажлын мэдээллийг загвар хүснэгтийн дагуу бэлтгэж, хэрэгжиж дууссан 9 дүүргийн 53 ажлаар танилцуулга бэлтгэж, 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/2346 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хагас жилийн байдлаар хүргүүлэв.

Дүгнэлт

Газрын 2024-2028 оны "Стратеги төлөвлөгөө"-г батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалын 04 дүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу Газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, Хариуцлагын гэрээний хамт 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатараар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 25/92 дугаар тогтоолоор "Хуулийн этгээдийн дүрэм шинэчлэн батлах тухай" газрын дүрэм шинэчлэгдэн батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг дүгнэх тухай" А/233 дугаарын захирамжаар манай газар "Бүрэн хангалттай" үнэлэгдэв.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг 2026 онд 12,421,424.00 мянган төгрөгийн орлоготой, 12,087,149.22 мянган төгрөгийн зардалтай, 300,847.31 мянган төгрөгийн цэвэр ашигтай байхаар төлөвлөсөн. 2026 оны 06 дугаар сарын 19-ний байдлаар 3,750,658.11 мянган төгрөгийн орлоготой, 3,545,960.65 мянган төгрөгийн зардалтай, 204,697.46 мянган төгрөгийн ашигтай ажиллаж байна.

Гэрээ болон гүйцэтгэлийг цаг алдалгүй цаг тухай бүрт нь хянан шалгаж, шаардлагатай тохиолдолд буцаан засуулж баталгаажуулан ажилласан. Мөн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн үнэлгээний хорооны зөвлөмжийг хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа, тендерийн хүчинтэй хугацаанд багтаан гэрээ байгуулан ажиллаж байна.

Бүх шатны шүүх болон бусад хуулийн байгууллагад байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнг тухай бүр газрын даргад танилцуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 66 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллан хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар эрх шилжиж ирсэн 238 төсөл, арга хэмжээний 234 ажлын техникийн тодорхойлолт болон даалгаврыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар болон архитектур төлөвлөлтийн даалгавруудыг худалдан авах ажиллагааны эрх шилжсэн байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

Бүтээн байгуулалтын ажлын мэдээллийг олон нийтэд түргэн шуурхай хүргэж, бэлтгэсэн мэдээ, мэдээллийг иргэдэд сонирхолтой, хүртээмжтэй байдлаар бэлтгэн газрын цахим хуудсыг хөгжүүлэн ажиллаж байна.

Цаашид авах арга хэмжээ

1. Газрын 2024-2028 оны "Стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажиллах,
2. Газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах,
3. 2026 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлтийг ханган ажиллах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах,
4. Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад оруулж, комисс ажиллуулах, баримт бичгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүлээлгэж өгөх,

5. Шинээр батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, Барилгын норм ба дүрэмтэй танилцан, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх,
6. Бүтээн байгуулалтын ажлын мэдээллийг газрын цахим хуудсаар олон нийтэд түргэн шуурхай хүргэх,
7. Шинэчлэх шаардлагатай журмын төсөл боловсруулан, газрын даргаар батлуулах.
8. Дээд газраас ирүүлсэн шийдвэрийн дагуу аян, хөтөлбөрүүдийг хугацаанд нь зохион байгуулах.
9. Шинээр батлагдсан Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх "20 минутын хотын стандарт", Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан нийслэлд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээг судлан, дүн шинжилгээ хийж, үр дүнгийн саналаа холбогдох газруудад хүргүүлэх.
10. Газарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын мэдээний танилцуулгыг шинэчилж, УИХ-ын гишүүд, НИТХ-ын төлөөлөгчид, холбогдох газруудад улирал бүр тогтмол хүргүүлж ажиллах.